



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Халаалтын улирал эхлэх,
дуусах хугацааг тогтоох тухай

Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол орны цаг агаарын ерөнхий төлөв байдлыг харгалзан халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг дараах байдлаар тус тус тогтоосугай.

а.Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотууд, дүүргүүдийн төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр;

б.Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Өвөрхангай, Завхан, Сэлэнгэ, Орхон, Төв, Увс, Хөвсгөл аймгуудын халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр;

в.Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгуудын халаалтын улирал эхлэх хугацааг тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр.

2.Тухайн бүс нутгийн гадна агаарын температуртай уялдуулан дулааны цахилгаан станцууд, дулааны станцууд дээр барих сүлжээний усны температурын график, даралтын горимыг батлах, батлагдсан горимын дагуу үйлдвэр компаниудаар мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Диспетчерийн үндэсний төв”-д үүрэг болгосугай.

3.Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэр, компаниудын дарга, захирал, аймгийн Засаг дарга нар дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилсугай.

а.Гадна агаарын температур буурч, өвлийн ачаалалд шилжихтэй холбогдуулан хот, суурин газрын дулаан хангамжийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор тухайн оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дулааны шугамнаас огтолгоо авч, сүлжээнд хэрэглэгч шинээр холбохгүй байх, аваар болон ослын бус шалтгаанаар дулаан хангамжийн ажиллагааг зогсоохгүй байх;

170600379

б.Халаалтын үргэлжлэх хугацаанд дулаанжуулалтын тоног төхөөрөмж, шугам сүлжээ болон хэрэглэгчийн шугам сүлжээний ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангах.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д үүрэг болгосугай.

САЙД



Н.ТАВИНБЭХ